

МОНГОЛ УРАН ЗОХИОЛ СУДЛАЛЫН ЗАРИМ АСУУДАЛ *

Ц. Дамдинсүрэн

Ази тивийн олон бага улсын дотроос монгол мэт олон эрдэмтний анхаарал татаж, түүх хэл бичгээ судлуулсан нь ховор гэж хэлж болно. Монголын түүх соёл, хэл зохиолыг судалсан эрдэмтэн, дэлхийн бөмбөрцгийн булан бүрт байгааг бид баярлан тэмдэглэж, тэр олон эрдэмтний ариун сайхан ажил хөдөлмөрийг амжилттай сайн болоосой гэж ерөөн хүсэж байна. Монгол хэл бичгийг Монгол, Орос, Хятад, Мажар, Герман, Япон, Америк, Фин зэрэг олон газрын эрдэмтэн судалж, үлэмжхэн үнэтэй чухал бүтээл гаргасныг хэн бүхэн мэдсээр буй. Энэ талаар хийсэн ажил үлэмж байвч, цаашид хийвэл зохих шаардлагат ажил зорилго нэн ч үлэмжхэн байна.

Юуны өмнө, Монголын судлалыг эрхлэх газрын хоорондын харилцаа, монголч эрдэмтний хоорондын харилцааг сайжруулах нь чухал байна. Хэн ямар зүйлийг судалж байгаагаа харилцан мэдэлцэж, монголын хэл бичгийн судлалын хоцрогдсон чухал хэсгийг олж, түүнд гол анхаарлаа тавих зэргээр монголч эрдэмтний ажил бүтээлийг зохицуулбал, монгол хэл бичгийн судлал улам амжилттай болно.

Монгол уран зохиолын түүх одоо хүртэл бичигдээгүй учраас, оюутан залуусыг өв соёлтой танилцуулан хүмүүжүүлэх ажил их орхигдож байна. Иймийн тул, монгол уран зохиол судлалын нэгэн гол зорилго бол, уран зохиолын түүхийг зохиох явдал болно. Үүний тул, урьдчилан өдий төдий ажил хийх хэрэгтэй.

Монголч эрдэмтэн Лауфер, 50 гаруй жилийн өмнө *“Монгол утга зохиолын найруулал”* гэдэг номдоо бичсэн нь: *“Урьдчилан хийвэл зохих чухал ажлыг хийгээгүй, цуглуулж аваагүй эрдэнэ бас үлэмж байх учраас, монгол утга зохиолын түүхийг бичиж бас болохгүй байна”* гэжээ. Өнгөрсөн таван жилийн дотор монгол утга зохиолын судлал нилээд урагш давшсан боловч, Лауферийн үгийг одоо давтан хэлэхэд алдаа бас болохгүй.

Лауферийн хэлсэн ёсоор, бидний олж мэдээгүй эрдэнэ, утга зохиолын дурсгалт ном зохиол үлэмжхэн байгаа тул, түүнийг эрж цуглуулах ажлыг улам эрчимтэй хийх хэрэгтэй. Ийнхүү эрэх сурвалжлах ажил нь горьдлогыг дүүрэн хангаж байна. Өвөр Монголд 1959 онд *“Алтан хааны намтар”* хэмээх уран шүлэглэл олдов. Ийм зохиол байдгийг бид сая болтол мэдэхгүй байлаа. Бас монгол Данжуур нэг бүрэн ижийг Цахарын нэг сүмээс олж авчээ. Монгол Ард Улсын Ховд аймгийн орон нутгийг судлах

* Studia Mongolica, Tom. I, Fasc. 24, Улаанбаатар, 1959, 1-24-р хуудас

кабинет, Хүрээ барын төвд Ганжуур нэг бүрнийг олж авчээ. Өмнөговь аймгийн орон нутгийг судлах кабинет, Болор толь хэмээх түүхийг олсон бөгөөд энэхүү Болор толь элбэг байдаг ном боловч, энд онцлон дурдаж байгаа учир бол, тэр хуулбарт Болор толийн зохиогчийн нэр дурджээ. Түүнийг урьд дундад хушууны даа лам Жамбадорж 1835 онд зохиосон байна. Энэ тухай түүхч Пэрлээ 1958 онд “Монголын хувьсгалын өмнөх үеийн түүхэн бичлэгийн асуудалд” хэмээх дэвтэрт тодорхойлон бичсэн билээ.

Энэ мэтээс үзэхэд мэдэгдээгүй ховор эрдэнийг хойшид үлэмжхэн олж болох нь тодорхой байна. Иймийн тул, хуучин ном бичгийг улам эрчимтэйгээр сурвалжилж цуглуулах хэрэгтэй байна.

Ном бичгийг цуглуулахын чухлыг дурдахын хамт, нэгэнт цуглуулсан номын бүртгэлийг хийж гаргах явдлын чухлыг бас дурдах хэрэгтэй. Улаанбаатар, Улаан-Үд, Хөх хот, Бээжин, Ленинград, Парис, Лондон, Нью-Йорк, Стокгольм, Будапешт, Токио зэрэг соёлын төв газар монгол номын чухал цуглуулбар номын сан байгааг бахдан тэмдэглэж болно. Харамсалтай нь, эдгээр номын сангийн монгол номын гүйцэд бүртгэл хэвлэгдэж гараагүй байна. Иймд, эдгээр номын санд байгаа монгол номын бүрэн сайн бүртгэлийг тодорхойллын хамт хийж гаргах нь, монгол утга зохиолын судлалыг амжилттай болгохын нэг эрхэм нөхцөл болно.

Монгол улсын номын санд байгаа монгол номын товч бүртгэлийг 1936 онд Цэвэл хийж гаргасан боловч, түүнээс хойш Монгол улсын номын санд үлэмжхэн ном нэмж цугларсан тул, шинэ нарийн сайн бүртгэлийг хийж хэвлэх нь чухал байна. Харин, энэ 1959 онд Монгол улсын номын санд байгаа зарим хэсэг номын бүртгэл хэвлэж гаргав. Ийм ажлыг цаашид үргэлжлүүлэх хэрэгтэй. Сүүлийн гурван зуун жилд Бээжинд модон бараар хэвлэсэн монгол номын бүртгэл тодорхойллыг Хейсиг багш хийж гаргасныг монгол утга зохиолын судлалын их амжилт гэж бид үзэж байна. Ленинградд байгаа монгол номын дотроос зөвхөн түүхийн номын бүртгэл тодорхойллыг эрдэмтэн Пучковский хийж гаргасан бөгөөд, бусад ном, ялангуяа уран зохиолын номын бүртгэл мэдээг хийж гаргаагүй. Европ, Америкад байгаа монгол номын зарим цуглуулбарын бүртгэл гарсан боловч, бүрэн үгүй. Ялангуяа, Бээжин, Токио, Улаан-Үд, Хөх хот зэрэг газрын номын бүртгэл гараагүй тул, тэр газарт ямар монгол ном байгааг бид мэдэхгүй байна.

Монголын ард түмэнд уран зохиолын баялаг өвөө бид тааварлан мэдэхээс бус, нарийвчлан мэддэггүй. Владимирцов багш, 1920 онд монголын утга зохиолын тухай өгүүллээ “*Монгол утга зохиол маш бага мэдэгдэж байна*” гэж хэлсэн билээ. Уран зохиолоо “Монголчууд өөрсдөө муу мэддэг, европын нийт хүмүүс ч байтугай, дорно дахиныг судлах ажлаар оролдогчид ч хүртэл муу мэддэг байна” гэж Владимирцов үнэнээр бичжээ. Ийм байдал, одоо хүртэл үргэлжилсээр байгаа учраас, уран зохиолын түүхийг бичиж болохгүй байна.

Монголын уран зохиолыг дутмаг мэдэж байсны нэгэн жишээг хэлбэл, Владимирцов, “*Бидэнд нэг ч монгол роман үзэгдээгүй байна*” гэж “*Монголын утга зохиол*” хэмээх өгүүлэлдээ бичсэн билээ. Монголын шүүмжлэгчид саявтар, Ринченгийн зохиосон “*Үүрийн туяа*” Лодойдамбын бичсэн “*Алтайд*” хэмээх зохиолуудыг монголын анхны роман гэж байлаа. Гэтэл арван есдүгээр зууны үед Өвөр Монголын зохиолч Инжинаашийн зохиосон, “*Хөх судар*”, “*Нэгэн давхар асар*” “*Улаанаа ухилах танхим*” хэмээх гурван гайхамшиг сайхан романыг Өвөр Монголын ардын хэвлэлийн хорооноос хэвлэн гаргалаа. Эдгээр зохиолыг судлах ажил амжилттайгаар эхэлж байна. Залуу эрдэмтэн Намжилцэвээн “*Инжинаашийн Хөх судар*” хэмээх эрдэм шинжилгээний

зохиолыг бичээд, 1959 онд Улаанбаатар хотноо хэл бичгийн ухааны дэд эрдэмтэн зэргийг олов.

Арван есдүгээр зууны эхний хагаст Халхад ноён хутагт Равжай гэдэг шүлэгч байжээ. Ард олны дотор их алдартай болсон энэ яруу найрагчийн тухай монголын судлагчид сая болтол мэдэхгүй байлаа. Одоо тэр зохиолчийн төвд хэлээр бичсэн хоёр зуугаад шүлэг, монгол хэлээр бичсэн нэг зуугаад шүлгийг бид эрж олоод байна. Равжайгийн шүлгийн дотор шажны номлолын шүлэг нилээд боловч, иргэний шүлэг, уул усны магтаал, утга уянгат шүлэг, янаг амрагийн шүлэг үлэмжхэн байна. Одоо цагт ихэд дэлгэрсэн “*Үлэмжийн чанар*”, “*Баян сүмбэр*” “*Урьхан хонгор салхи*” зэрэг ардын дууны үг аялгууг Равжай зохиосон байна.

“*Саран хөхөөний тууж*”-аас үндэслэсэн дуулалт жүжгийг арван есдүгээр зууны эцэс, хорьдугаар эхээр Говь мэргэн вангийн өргөө, хүүхэн хутагтын хүрээ зэрэг газар тоглож байсан тодорхой баримт байдаг.

Равжайгийн намтраас үзвэл Саран хөхөөний тухай жүжгийг 1833 онд Равжай дэглэж, Тулгатын хийд дээр анх тоглосон гэж байна. Үүнээс үзвэл, яруу найрагч Равжай бол, монголд иргэний дуурь жүжгийг зохиож гаргасан урлагийн эрхэм зүтгэлтэн хүн байжээ.

Тулгатын хийд нь, цахар нутгийн сүм бололтой. Гэвч, Равжайгийн бүрэн намтрыг бид эрж олоогүй, түүний намтрын хэдэн уранхай хуудсыг олж үзсэн төдий тул, тэр зохиолчийн үйл амьдралыг тодорхой мэдэж чадаагүй байна.

Равжайгийн зохиосон говийн Галбын уулын магтаал дуу нь:

Гайхамшгаар бүтсэн
Галбын тэр ууланд
Гадна дотно хоёроос
Гажуу дайсан үгүй л
Эелдэг цасан тэргүүнтэй
Элдэв цэцгийн цамцтай
Эрээн зүлгэн хормойтой
Эрдэм төгс орон юм.
Сайхан Галбарваасан модны
Салаа навч найгаад
Сацлалтгүй шидтэнийг
Санан даллах байдалтай
Урсгал булгийн ус нь
Уятай сониноор мэлмэрээд
Ухаан төгс мэргэдийг
Угтан залах адил.
Урьхан тоть шувуу нь
Уянгатай сониноор донгодон
Утгийг санасан сэтгэлий нь
Улам улам хөгжөөнө.
Хүчир их хад нь
Хүрээлэн байхы нь үзвэл
Хүний найман номоос
Хүсэн сурах янзтай.
Гурвалжин үүдтэй агуй нь

Гурван цагийн тохиол
Гуйвалтгүй сэтгэлээр
Гурван биеийг бүтээлтэй.

Равжайгийн хэдэн шүлэг, төвд хэлээр модон бараар урьдын цагт хэвлэгдсэнээс өөр, олонхи зохиол нь ер хэвлэгдсэнгүй, ард олны дунд бичмэлээр дэлгэрчээ. Энэ зохиолчийн зохиолыг эрж олох, хэвлэх судлахын чухлыг хэлээд яах вэ. Цааш нь, Равжай шиг ийм билэгтэй яруу найрагч хичнээн байсныг бид мэдэж чадаагүй нь үнэхээр харамсалтай.

Монголын уран зохиолын дурсгалт бичгийг хэвлэж гаргах талаар монголчууд, бусад орны эрдэмтэн, нилээд ажиллаж их олон ном бичиг хэвлэсэн билээ. Нууц товчоо, Гэсэрийн тууж, Жангарын туульсын зэрэг олон зохиол хэвлэгдэв. Гэвч, цаашид хэвлэхийг хүлээж байгаа зохиол нэн ч үлэмж байна. Жишээлбэл, алдарт Гэсэрийн туужийн олонхи хувилбар хэвлэгдээгүй байлаа. Харин энэ удаагийн монголч эрдэмтэн нарын хурлын өмнөхөн *“Лин Гэсэр”*, *“Заяын Гэсэр”* хоёр хэвлэгдэн гарав. Владимирцов багшийн судалж хэвлэсэн *“Банздандраас авсан монгол өгүүллэгийн цоморлиг”* хэмээх зохиол бол, монгол уран зохиолын дурсгалт бичгийг яаж судалж, яаж хэвлэвэл зохихын жишээ болохуйц ном гэж хэлж болно. Энэ мэтээр зохиол судалж хэвлэх ажлыг хийвэл их л сайн санжээ.

Монгол зохиолыг бусад хэлэнд орчуулж хэвлэх талаар Шмидт, Юльг нараас эхлээд Владимирцов, Козин, Санжеев, Мостаерт, Кливз, Поуха нар хүртэл их юм бүтээжээ. Цаашид энэ мэтээр монгол зохиолын шилдэг жишээг олноор бусад хэлэн дээр орчуулан хэвлэж байвал, монголч эрдэмтнээр барахгүй, нийт уншигчид, утга зохиолын судлалтанд хүртээмж болох ачтай байна.

Уран зохиолын судлалыг хийхэд ерөнхий тойм өгүүлэл, уран зохиолын жишээг үзүүлсэн дээж бичиг чухал болох нь илэрхий билээ. Дээд сургуулийн оюутанд зориулсан Попов, Ковалевский, Позднеев нарын дээж бичиг, тухайн үедээ үлэмж ач тус хүргэсэн боловч, одоо хуучирсан бөгөөд ховор болжээ. Монгол хэл бичгийг судалж байгаа оюутан нарт зориулан *“Монгол уран зохиолын дээж зуун билиг оршив”* хэмээх бичгийг 1959 онд бид хэвлэж гаргав. Энэ дээж бол, урьдын дэж бичгүүдээс багтаасан материалын талаар, зохиолыг сонгож авсны талаар шат ахисан боловч, бидний хүсвэл зохих хэмжээнд хүрсэн нь хэрхэвч бус, орвол зохих зохиолыг олж оруулж чадаагүй, заримдаа санамсаргүй зохиолыг оруулсан, тайлбар дутуу дулим болсон зэргийн олон дутагдал энэ дээж бичигт буй. Иймийн тул, үүнийг нөхөн засаж, нэг сайн дээж бичиг болгохыг бид зорьж байна.

Уран зохиолыг судлахдаа, шажны зохиол, феодалын зохиол, ардын зохиол гэх зэргээр анги урсгалаар ялган салгаж судлахыг чухал гэж үзэж байна. Зарим эрдэмтэн, монгол уран зохиолыг судлахдаа феодалын үеийн зохиолыг цөм феодалын зохиол гэж үзэх эндүүрэл байсан. Жишээлбэл, эрдэмтэн Поппе, 1935 онд *“хувьсгалын өмнөх үеийн Буриад Монголын зохиолыг ерөнхийд нь феодалын гэж шууд хэлж болно”* гэж бичсэн (Записки института востоковедения АН СССР, III, стр.) ба *“Хувьсгалын өмнөх Буриад Монголын соёл нь чанартаа феодалын соёл”* гэж бичсэн нь арай хилстүүлсэн болбуу гэж бид санаж байна. Жишээлбэл, 18-19-р зууны үеэс Буриадын эрдэмтэн, олон ном орчуулж, зохиож хэвлэсэн, монгол бичгийг өргөнөөр хэрэглэх болсон зэргийг цөм феодалын соёл гэж дүгнэж арай болохгүй.

“Феодалын үеийн бичгийн зохиол бол..... феодал ангийг үйлчилж байлаа” гэж Зөвлөлтийн нэвтэрхий толинд бичсэн нь, бас дэндүү цулгүй дүгнэлт болсон байна.

Хувьсгалын өмнө Монголын феодад ноёдоос гадна ерийн бичиг мэдэх хүмүүс, хоёр загалын тууж, Гэсэрийн тууж, Хуримын ерөөл, Гучин хоёр модон хүний үлгэр, Хар үхэрт хүүгийн тууж зэрэг феодалын ном гэж хэлж болмооргүй зохиолыг сонирхон уншсаар хэрэглэсээр байсан. Феодалын ёс суртлыг баримталсан, бурхны шажныг номлосон чиглэлийн уран зохиол ихэнх суурийг эзэлж байсан гэж хэлж болох бөгөөд, гагцхүү монголын хуучин уран зохиолыг цөмөөр феодалын уран зохиол гэвэл, хэтэрсэн үг болох нь зайлшгүй.

Феодалын нийгэмлэгийн үед монгол оронд феодад ард хоёр анги байсан тул, тэр хоёр ангийн ашиг тусыг баримталсан хоёр чигэлийн соёл уран зохиол байсан гэж бид үзэж байна.

Ойрд, Халх, Буриад, Өвөрлөгчдийн хэл нь тусгай, уран зохиол нь ч тусгай тул нийт монголын уран зохиолын түүхийг бичиж болохгүй тус тусад нь бичих хэрэгтэй гэж зарим эрдэмтэн хэлдэг. Энэ саналыг 20р зууны үеийн утга зохиолын түүхийг хэлэцэхэд харгалзаж үзэх нь зүйтэй бөгөөд, 19р зууны үеийг хүртэлх утга зохиолын түүхийг судлахад яг баримталж болохгүй гэж бодож байна. Учир нь монголчууд улс төр, эдийн засгийн талаар нэгдмэлгүй болж бутарсан боловч, соёлын хэлхээ нилээд бат байсаар ирсэн тул, нийт монголын утга зохиолын түүх гэж хэлэлцэж болох, хэлэх ч ёстой гэж үзэж байна.

Монгол, Ойрдын хоорондын соёл, утга зохиолын харилцаа үлэмж байсны ганц хоёр баримтыг гаргавал, Ойрдын Зая бандидын орчуулсан Мань ганбум Бээжинд модон бараар хэвлэгдэж, нийт монголчуудад дэлгэрсэн байна. хэвлэгдсэн Монгол Гэсэрийн тууж, тод үсгээр хуулан бичигдээд, Ойрд халимагт түгээмэл дэлгэрсээр байжээ. Хоёр Дарь эхийн тууж, Үлгэрийн далай, Гэсэрийн тууж, Хар үхэрт хөвгүүний тууж, Багш шавийн үлгэр зэрэг олон ном халимаг, халх, харчин, буриад алинд ч ялгалгүй дэлгэрч хэрэглэсээр байлаа. Монголын урьдын зохиолын олонхийг нь энэ нь Буриадын юм, энэ нь Халхын юм гэх буюу энэ нь Ордосын юм, энэ нь Ойрдын юм гэж ялгахад хэцүү байдаг.

Харин 20р зууны үед халимаг, буриад, халх зэрэг монгол аймгийн шинэ утга зохиол өвөрмөц замаар хөгжиж байгаа тул, түүхийг нь ч мөн тусгайлан судалж бичих хэрэгтэй болов. Монгол ард улсын шинэ уран зохиолын түүхийн найруулал хэмээх номыг Зөвлөлтийн эрдэмтэн Михайлов зохиож хэвлүүлээд, хэдэн жил болж байна. бас монгол хэл бичгийн багш Цэнд, дунд сургуульд зориулан энэ тухай тусгай ном бичив. Буриадын шинэ уран зохиолын сурах бичгийг Шаракшинова зохион гаргажээ. Монголчуудын соёлын их сэргэлтийн үе болсон тул, уран зохиолын шинэ шинэ төрөл буй болон дэлгэрч, уран зохиол олноор хэвлэгдэж, түүнийг судлах ажил ч бас амжилттай хөгжиж байна.

Монголчуудын улс төр, эдийн засгийн талаар бутархай сарниун байгаа байдал нь, соёлын талаар аргагүй бутрангуй байдалд оруулж байгаа боловч одоо үеийн найрамдалт үндэстнээр хүрээлэгдэж, харилцааны хэрэглэгдэхүүн сайжирсан бололцоог ашиглаж соёлынхоо харилцааг сайжруулж, хэл бичиг, зохиол соёлоо хамтран хөгжүүлэх нөхцлийг буй болгожээ. Энэ сайхан бололцоог ашиглаж чадах эсэх нь, ихэнхдээ монголчуудын өөрсдийн идэвх санаачлагаас шалтгаална. Монголын уран зохиолын түүхэнд, монгол хэлээр бичсэн зохиолоос гадна, бусад хэлээр, төвд хэлээр монгол хүний бичсэн уран зохиолууд орох ёстой. Төвд хэл бол сүүлийн хэдэн зуун жилийн дотор монголын хоёрдугаар бичгийн хэл болж төвд хэлээр бичдэг монгол зохиолчид олон гарч түүнийг уншиж хэрэглэдэг монгол хүмүүс ч үлэмжхэн байжээ.

Төвд хэлээр уран зохиол бичсэн олон монгол зохиолчдын зохиолыг судлан үзэж зохих ёсоор үнэлэн монголын уран зохиолын түүхэнд оруулах нь одоогийн чухал зорилгын нэг болно. Энэ хир бид тийм зуугаад зохиолчдын нэр зарим зохиолыг мэдэх төдийгөөс хэтэрч чадаагүй бөгөөд тэр зохиолыг судлах талаар бараг юу ч хийж чадаагүй байна.

Утга зохиолын түүхэнд орчуулгын зохиолыг авч хэлэлцэх нь зүйтэй юм. Тэгэхдээ харгалзвал зохих гол зүйлийг дурдвал:

Нэгд. Тэр орчуулгын зохиол нь аль хир өргөн хэрэгцээтэй байсныг харгалзана. Жишээлбэл төвдөөс орчуулсан Үлгэрийн далай бол Монгол түгээмэл дэлгэрч, монголчуудын соёл хүмүүжил багагүй нөлөө үзүүлжээ. Ийм зохиолыг эрхбиш уран зохиолын түүхэнд оруулна. Тэрчлэн хятад хэлнээс орчуулсан сонгодог роман, орос хэлнээс сүүлийн үед орчуулсан Зөвлөлтийн зохиол, Монголын дотор өргөн уншигчидтай болж нийт соёлд их нөлөөлөн байна.

Хоёрт. Орчуулагдсан зохиол нь адил төлөвөөр зохиолуудыг бүтээхэд түлхэц болж нөлөөлөн уран зохиолын хүрээлэлтэй болсон бол уг зохиолыг авч хэлэлцэнэ. Ийм зохиолын тоонд Саж бандид Гунгаажалцаны зохиосон *“Эрдэнийн сан сувшиди”*-ийг оруулж болно.

Гуравт. Орчуулсан зохиол нь улмаар хувирч монголын ахуй байдлыг тусган монголын өвөрмөч шинж олсон бол авч хэлэлцэнэ. Ийм зохиолын тоонд Ушаандар хааны тууж, Шидэт хүүрийн үлгэр, Хятадын зарим роман тууж зэргийг оруулж болно. Монгол орчуулгын зохиолыг судлах явдал, дөнгөж үүсвэрийн төдий байгаа тул цаашдаа судалмагц урьд энэ талаар таамаглаж байсан зүйлийг өөрчлөх явдал цөөнгүй гарах бизээ. Жишээлбэл: зарим эрдэмтэн Дарь эхийн туужийг түвд хэлнээс орчуулсан гэдэг боловч нотолгоо байхгүй. Түвд хэлээр монгол Дар эхийн туужнуудтай тохирох зохиол олдохгүй байгаа бөгөөд олдсон Төвд Дарь эхийн тууж нь монгол Дарь эхийн туужнуудаас огт өөр зохиол байна. Төвд Дар эхийн тууж гэж Даранатын зохиосон Дар эхийн тууж хэмээх номыг хэлж байна. Энэ зохиолын дотор Дарь эх бурханд залбирсны ачаар хулгай дээрэм, араатан, түймэр зэргийн аюулаас ангижирсныг өгүүлсэн арван найман бяцхан үлгэр байв. Эдгээр нь урлагаар дорой, богинохон өгүүллүүд байх бөгөөд монгол Цагаан Дарь эхийн тууж буюу Наран гэрэл дагины тууж бол роман буюу тууж гэж нэрлэж болохуйц жинхэнэ уран зохиол байна. Ялангуяа Ногоон Дарь эхийн тууж бол монголын яруу шүлгийн зохиол гэж санагдаж байна.

“Бягармижид хааны алтан ширээний түүх”-ийг төвдөөс орчуулсан гэж санаж байсан боловч түүний гуравдугаар хэсэг болох *“Гэсэнэ хааны тууж”*-ийг Төвдөөс орчуулсан бус Өндөр гэгээний шадар Чулуун хуруут азар, 17-р зууны үед Энэтхэгийн хэлнээс Монгол хэлэнд орчуулсан нь мөн номын төгсгөлийн үгэнд тодорхой байна. Үүнээс үзэхэд урьд төвд хэлнээс орчуулсан гэж эрдэмтэн нарын таамаглаж байсан зохиолын нилээд нь монгол зохиол болох ба зарчим нь төвд хэлнээс бус өөр хэлнээс орчуулсан болж байна. жинхэнэ төвд хэлнээс орчуулсан зохиолын ихэнхийг бид хэдийд хэн орчуулсныг их төлөв мэдэж чадаагүй байна. *“Саран хөхөө шувууны тууж”*-ийг Шилийн голын Агваандампил орчуулсан, *“Наганзанын рашааны дусал”*-ыг цахар гэвш Лувсанчүлтэм орчуулсан, *“Милын дуулал”*-ыг Гүүш Цорж орчуулсан зэргийг мэдэж байгаа боловч *“Шидэт хүүр”*-ийг ямар хэлнээс хэн орчуулсан, Чойжод дагины туужийг хэн хэдийд орчуулсан Очироор огтлогчийн тус эрдмийг тайлсан судрыг хэн, хэдийд орчуулсан зэргийг огт мэдэж чадаагүй байна.

Ялангуяа төвдөөс орчуулсан зохиолд Монгол амьсгал оруулж улируулан монгол зохиолын шинжтэй болгосныг мэдэх явдалд их нарийн нямбай судлал хэрэгтэй байна. Владимирцов багш, *“Банздандараас авсан монгол үлгэрийн цоморлог”* гэдэг алдарт номдоо тэрхүү зохиолын монголжсон байдлыг авч үзсэн билээ. Түүнээс хойш Владимирцовын үүсгэсэн энэ чухал сонин судлалыг үрэгжлүүлсэнгүй, мартаж орхиход хүрсэн нь, монгол утга зохиолын судлалын ноцтой дутагдал болно. Орчуулсан зохиол нь улирсаар монгол зохиол болох байдлыг онц чухалчлан судлах нь одоогийн монгол зохиолын судлалын нэг чухал зорилго мөн.

Орчуулгын зохиолын судлалын дотор хятад хэлнээс орчуулсан зохиолыг судлах ажил эрхэм суурийг эзэлнэ. Гэтэл хятад хэлнээс орчуулсан зохиолыг судлах ажил дөнгөж үүсгэлийн чанартай байна. Монгол хэлэнд хятадын ямар ямар зохиол байгааг ч бүртгэн мэдэж чадаагүй байна. Хятадаас орчуулсан олон роман бичмэлээр монголын дотор дэлгэрснийг бид мэдэж байна. Гэвч ихэнх романыг хэдийд хэн орчуулсныг шалгаруулан олж судалж чадаагүй байна. Сонгодог романы зарим нь хэд хэд орчуулагдсан байна. Жишээ нь: Алдарт гурван улсын бичиг хэмээх роман лав гурван удаа орчуулагджээ. Позднеевийн эмхтгэсэн монгол зохиолын дээж бичигт байгаа гурван улсын түүхийн хэсэг нь, Тэмгээтийн хэвлүүлснээс өөр орчуулга байна. Тэрчлэн Монгол улсын номын санд бичмэлээр байгаа гурван улсын бичигт хэмээх роман бас өөр орчуулгатай байна.

Хятад романыг ард түмний дунд дэлгэрүүлэхэд, үлгэрч хуурч нар их ачтай ажлыг хийсээр байна. Хятад романыг хуурдан дуулдаг мэргэжилтэй хуурч нар ч байна. Халхын Лувсан хуурч, Норов хуурч нар, Хятадын романыг хуурдан дуулдаг байлаа. Одоо Өвөр монголын Пажай, Мууохин зэргийн алдартай хуурч нарын дуулдаг зүйлийн дотор хятад роман чухал суурийг эзэлж байна. Пажай хуурчийн дуулсан Шүй Ху бичгийн бүлэг нь хятад их бичгээс их өөр, хэд дахин нэмж их болгоод уран шүлгээр өгүүлсэн зохиол байна. Хятадын Шүй ху бичгийн доторх үйл явдлыг дагуулан Пажай хуурчийн зохиосон романыг өөр роман гэж үзэхээс өөр аргагүй. Түүний хуурдсан романд, үргэлжилсэн яриа шүлэг ээлжлэн явах нь Нууц товчооны хэлбэртэй их л адил байна. 13-р зууны үед тэр цагийн түүхийн тэмдэглэлийг дагуулан Пажай мэт билигтэй хуурч хуурдан дуулж, Нууц товчоог зохиосон болов уу хэмээн санагдуулж байна. Пажай, Мууохин, бусад үлгэрч нарын хэлдэг роман үлгэр бол монголын уран зохиолын нэг өвөрмөц сонин хэлбэр мөн тул, эдгээр роман үлгэрийг бичиж аваад судлах нь чухал байна.

Хятадаас орчуулсан маягтай зохиол, хятадаас орчуулав гэсэн зохиол бүрийг орчуулгын зохиол гэж үзэж болохгүй., тус бүрд нь хянан судлах хэрэгтэй. Монголын зарим зохиолчид, ямар нэгэн шалтгаанаар зохиолоо булзааруулж бусдын зохиол гэх буюу бичсэн зохиолоо бусад хэлээс орчуулав гэх явдал нилээд байжээ. Жишээлбэл, алдарт зохиолч Инжинааш *“Нэгэн давхар асар”* хэмээх романаа *“Линхэ газрын Циүвин овогт Жиншан сяниен найруулсныг монголоор орчуулав”* гэж оршил бичиж, орчуулгын зохиол мэт болгож, *“Улаанаа ухилах танхим”* хэмээх романы оршилд эцгийнхээ хятад нэрийг эзэлж *“Цэгээн овогт Жинсан сяниен-гийн зохиолыг орчуулав”* гэж бичжээ. Энэ хоёр роман хоёулаа Инжинаашийн өөрийн зохиол болох нь хожим нотлогдсон юм.

Өвөр монголын зүүн хэсэгт ихэд дэлгэрсэн таван жуаны бичиг хэмээх тавах их роман байх бөгөөд эдгээрийг Хятадаас орчуулсан мэтээр хэлэлцдэг боловч чухамдаа хүн, монгол хэлээр зохиосон роман бололтой. Эдгээр зохиолыг хэвлээгүй судлаагүй тул энэ хир шийдвэртэй үгийг хэлэх аргагүй байна.

Урьд дурдсан монгол зохиолын судлалын талаар хойшид хийх ажил нэн үлэмж байна. Монголын өсөж бойжиж байгаа эрдэмтэн, гадаад олон орны эрдэмтэнтэй хүчээ хавсран ажиллавал, тэр их ажлыг улам амжилттайгаар гүйцэтгэж дэлхий дахины эрдэм ухаанд ба Монголын судлалд их нэмрийг оруулж лавтай чадна гэж гүнээ итгэж байна.

РЕЗЮМЕ

История и языка монгольских народов изучены сравнительно хорошо. Однако, в области монгольской филологии еще остается много неразрешенных задач, разрешение которых требует тесного контакта и совместного усилия научных учреждений, ученых монголистов разных стран

История монгольской литературы еще не написана. Созданию такой истории должно предшествовать собрание литературных памятников, издание текстов и их переводов с комментариями, хрестоматий, сборников и монографий.

Автор критикует ошибочные взгляды некоторых ученых (Н.Н.Поппе и др) считавших всю старую литературу монголов феодальной. Полемизируя с некоторыми учеными автор приходит к выводу, что до XX века существовала единая монгольская литература.

История монгольской литературы по мнению автора должна включать также и произведения монгольских авторов, писавших свои сочинения на иностранных языках (например, ина тибетском языке).

Переводные литературные произведения также должны занять определенное место в истории монгольской литературы, если они:

а. Имели широкое хождение среди монголов и повлияли на их общую культуру (например "море притч"),

б. Побудили к созданию подобного типа произведений у монголов, постепенно приобретая некое литературное окружение (например, "Сумашида" и др)

в. Изменяясь под влиянием окружающей среды и подвергаясь переработке приобрели специфически монгольский характер (например, "Повесть об Ушандаре", "Золшебный мертвец" и др.)